



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/565.

Улаанбаатар хот

“Хан-Уул дүүргийн 145 дугаар цэцэрлэгийн”
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хан-Уул дүүргийн 145 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 18 нэр төрлийн нийт 6,756,731.94 (зургаан сая долоон зуун тавин зургаан мянга долоон зуун гучин нэгэн төгрөг ерэн дөрвөн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 145 дугаар цэцэрлэг (Ч.Янжиндулам)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 14 нэр төрлийн 3,434,100.00 (гурван дөрвөн зуун гучин дөрвөн мянга нэг зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг устгалын акт үйлдэн устгах, татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 4 нэр төрлийн 3,322,631.94 (гурван сая гурван зуун хорин хоёр мянга зургаан зуун гучин нэгэн төгрөг ерэн дөрвөн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Хан-Уул дүүргийн 145 дугаар цэцэрлэг (Ч.Янжиндулам)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  В.ОЮУМАА



1150501295

Нийслэлийн Өмчийн харилцаа, гэрээ, хамтын ажиллагаа, хөрөнгийн хөгжлийн газрын 2024 оны 1^{дү} дугаар өдрийн А/565 дугаар тушаал

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 145 дугаар цэцэрлэг

[illegible]

Татан төвлөрүүлэх	3,322,631.94					
Устгах хөрөнгө	3,434,100.00					
Худалдсанаас олох орлого						
НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/						